ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 07 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2021.07.21 **Дархан**

1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Геодези, зураг зүйн чиглэлээр:

Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй "Гео од", "Ёлт сүрвэй", "Онч сервэй" ХХК-ний хийж гүйцэтгэсэн доорхи ажлыг шалгаж хүлээн авсан. Үүнд:

1. Дархан сум 14 дүгээр баг. Миний Монгол" цэцэрлэгт хүрээлэн авто зогсоол, хөлбөмбөгийн талбай /улаан шугам/
2. Хонгор сум 1 дүгээр баг "Дархан арьс ширний цогцолбор" ОНӨХХК/ Бог малын ноосгүй арьс боловсруулах үйлдвэр, бод малын арьс боловсруулах үйлдвэр /Улаан шугам/ /Улаан шугам/
3. Дархан сум 12 джгаар баг. 13-р хороолол Үндэсний эрх чөлөөний 3-р гудамж 317 тоот 108 айлын орон сууцны барилга /улаан шугам/
4. Шарын гол сум. Шайзгатын хорооллоос тосгоны эцсийн буудал, эрүүл мэндийн төвийн арын тойрогоос гандангийн тойрог хүртлэх хатуу хучилттай авто замын өргөтгөл. /улаан шугам/
5. Дархан сум 14 дүгээр баг. Нэгдсэн эмнэлэгийн авто зогсоол /Гүйцэтгэл/
6. Дархан сум 15 дугаар баг. "Дэлгэрэх бат дэвжих" ХХК-ний үйлчилгээний төвийн гадна цахилгаан хангамж. /улаан шугам/
7. Дархан сум 10 дугаар баг "Хийморь Гарден" хотхоны 144 айлын орон сууц. /улаан шугам/
8. Дархан сум. 8-р багийг 1-р багтай холбох авто зам. /Улаан шугам/
9. Хаягийн зургийн дагуу 20 иргэн, 7 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.
10. Цагдаагийн газраас газар зүйн байршлыг тогтоолгохоор ирүүлсэн 13-н цэгийн солбицолыг зурагт оруулж байршлыг тодорхойлон Цагдаагийн газарт хүргүүлсэн.
11. Дархан сум. 1,3,8,13,15 дугаар баг "Дэд бүтэцийн хөгжил-Баянзүрх, Дархан, Сэлэнгэ төсөл" гудамжны гэрэлтүүлгийн ажил. /улаан шугам/
12. Орхон сум 1 дүгээр баг Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /улаан шугам/
13. Дархан сум Малчин баг Үнсэн сан №2 сэргээн байгуулах. /улаан шугам/
14. Хонгор сум 1 дүгээр баг Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга. /улаан шугам/

Орхон сумын мэдээ:

Газрын харилцаа, газар зохион байгуулалтын чиглэлээр

- Сумын засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/93 тоот захирамжийн дагуу 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах нийт 12 хүсэлт хүлээн авсан байна. Мөн газартай холбоотой мэдээллийг 55 иргэнд өгч ажиллаа. Газрын өмчлөх 7, өмчилсөн газрын талбай хэмжээ өөрчлөх 1, эзэмшил газрын талбай хэмжээ өөрчлөх 4, газар эзэмших эрх эзэмших газрын эрх шилжих 3, газрын барьцаа 2, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газраа худалдах худалдан авах 15, Газар эзэмших гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 8, нийт 40 өргөдлийг шийдвэрлэлээ.

Газрын кадастр, бүртгэл чиглэлээр

- Газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 12 иргэний газарт Э дугаар авахаар Дархан-уул аймгийн улсын бүртгэл рүү илгээж 10 иргэний Э дугаар ирсэн үүнээс 9 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг бичиж гэрээ байгуулсан. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж авсан иргэний худалдах худалдан авах гэрээ 15, кадастрын зургаар 52 иргэнд үйлчилсэн.

Газрын төлбөр болон газар эзэмших дуудлага худалдааны чиглэлээр:

- Тайлант хугацаанд 3 иргэнтэй газрын төлбөрийн тооцоо нийлж урьд оны үлдэгдэл газрын төлбөрөөс 419 000 төгрөг төлүүлсэн.
- Шинээр гэрээ байгуулсан 9 иргэний газарт газрын төлбөрийн нэхэмжлэл үүсгэн татварын газарт хүргүүлсэн.

Газрын татвар, төлбөрийн хүрээнд:

- Аймгийн Засаг даргын 2021.05.20-ний өдрийн 01-А/157 дугаар захирамжаар Дархан сумын 8, 13-р багт 3 нэгж талбарт дуудлага худалдааг 2021.06.24-ний өдөр зохион байгуулсан. Дархан сумын 13-р баг 30-р хороолол, Үйлдвэрчний 1-144 тоот хаягт байрлах 9334м.кв худалдаа, үйлчилгээний зориулалттай газарт 2 оролцогч оролцож, 277618400 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.
- Санхүүгийн хяналт, Аудитын албанаас хяналт шалгалт явуулж байгаатай холбоотой газрын төлбөр нөхөн ногдуулах, 223 иргэн, хуулийн этгээдийн төлөлт, ногдуулалтыг шалгаж нөхөн ногдууллаа. Мөн аймгийн Татварын хэлтэс, манай байгууллага хоорондын төлөлтийн зөрүүтэй иргэн, хуулийн этгээдийн төлбөрийг хянах, төлөлтийг тулгах ажлыг Аудитын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, шаардлагатай мэдээллийг цаг тухай бүрт нь гаргаж өгч ажиллалаа.
- Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021.07.06 -ны өдрийн 01-А/196 дүгээр захирамжийн дагуу газар эзэмшүүлэх дуудлага худалдааг 2021.07.30 -ны өдөр газрын биржийн цахим систем **/www.mle.mn/-ээр** зохион байгуулна.
- Дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг **2021.07.23-2021.07.29-ны өдрийн 15:00 цаг 00 минут хүртэл** www.mle.mn цахим системээр хүлээн авч, баталгаажуулна. Дуудлага худалдаа 2021.07.30-ний өдрийн 09:00-17:00 цагийн хооронд явагдана.

- Төсөл сонгон шалгаруулалтын **битүүмжилсэн материалыг 2021.07.21-2021-07-27-ны өдрийн 09:00-17:00 цаг хүртэл Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт** хүлээн авч байна.Төсөл сонгон шалгаруулалтын битүүмжилсэн материалыг хүлээн авах хугацаа дууссан өдрөөс хойш ажлын 5 өдөр буюу 2021.08.03-ны өдөр зохион байгуулахаар ажиллаж байна.

2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Инженерийн дэд бүтцийн хүрээнд:

- 5-р багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил дуусч байнгын ашиглалтад оруулах комиссын нарийн бичгээр ажиллаж ашиглалтад оруулсан.
- Дархан сум, 13-р баг үйлдвэрийн раойн Бурхант эко асфальт компанийн 6кВ цахилгааны агаарын шугамын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт өгсөний дагуу холбогдох техникийн бичиг баримтыг судлаж ажил эхлэх зөвшөөрөл олгосон.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймаг, Орхон суманд баригдах 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт өгсөний дагуу холбогдох техникийн бичиг баримтыг судлаж ажил эхлэх зөвшөөрөл олгосон.
- Хонгор сум, Үржил шимт яргайт ХХК- ийн 6кВ цахилгааны агаарын шугамын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт өгсөний дагуу холбогдох техникийн бичиг баримтыг судлаж ажил эхлэх зөвшөөрөл олгосон.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймаг, Дархан сум 12-р баг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт өгсөний дагуу холбогдох техникийн бичиг баримтыг судлаж ажил эхлэх зөвшөөрөл олгосон.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймаг, Дархан сум 13-р баг Аюултай хог хаягдал агуулах барилгын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт өгсөний дагуу холбогдох техникийн бичиг баримтыг судлаж ажил эхлэх зөвшөөрөл олгосон.
- Захиалагчийн техник хяналт хэрэгжүүлж буй 3 барилга байгууламжийн ажлын явцыг үзэж аймгийн Засаг дарга болон ХОХБТХ-т 2 удаа танилцуулсан.
- МОН3244/3245 төслийн хүрээнд цэвэрлэх байгууламжийн барилга байгууламжийн гадна инженерийн шугам сүлжээний ажил эхлэх зөвшөөрөл авах хүсэлтийн дагуу техникийн бичиг баримтыг судлаж ажил эхлэх зөвшөөрөл олгосон.
- Дархан сум, 10-р баг, иргэн Б.Одгаригийн 144 айлын орон сууцны барилгын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийн материалыг судлаж ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон.

Хот байгуулалтын кадастр, зурагт төслийн чиглэл:

- ААН, иргэний байршлын зураг 13-г боловсруулж өгөв
- Архитектур төлөвлөлтийн даалгавар 8-г боловсруулж хянуулан батлуулав
- Хот байгуулалтын кадастртай холбоотой мэдээ , судалгааг цаг тухайд нь гаргаж хүргүүлсэн.
- Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд дутуу мэдээллийг нөхөн оруулж байна.
- Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангаар буюу цахим системээр 2 барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг гаргасан.



3. ЗАХИРГАА УДИРДЛАГЫН АЖИЛ:

Сургалтын чиглэлээр:

- Төрийн албаны болон архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, стандартын талаарх мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх зорилгоор ТАЗөвлөлөөс цахимаар зохион байгуулагдсан сургалтад 4 албан хаагч хамрагдсан.

Дотоод ажил:

Үйлдвэрлэлийн дадлага:

- Монгол улсын их сургуулийн “Газарзүйн тэнхим”-ийн “Газар зохион байгуулалтын кадастр” мэргэжлийн 4-р дамжааны оюутан Эрдэнэшиш овогтой Мөнгөнцэцэгийн үйлдвэрлэлийн дадлагын ажил хийлгүүлэх удирдамжыг удирдлага болгон 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс 07 дугаар сарын 21-ийг өдрийг дуустал, Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн “Агроэкологи Бизнесийн Сургууль”-ийн “Газар зохион байгуулалтын инженер” мэргэжлийн 3-р дамжааны оюутан Цоггэрэл овогтой Бүжин, Бямбасүрэн овогтой Будсүрэн, Чулуунбаатар овогтой Нандинцэцэг, Монгол улсын их сургуулийн “Газарзүйн тэнхим”-ийн “Хот бүс нутаг төлөвлөлт” мэргэжлийн 4-р дамжааны оюутан Ганзориг овогтой Анар нарыг үйлдвэрлэлийн дадлагын гэрээг удирдлага болгон 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 08 дугаар сарын 02-ны өдрийг дуустал хугацаанд үйлдвэрлэлийн дадлагыг ГУХэлтсийн мэргэжилтнүүдээр удирдуулж удирдамж болон гэрээний дагуу хийлгүүлж байна.

- Баяр наадмын нийтийн амралтын өдөр 07 дугаар сарын 10-наас 18-ны хооронд байгууллага дээр 9 албан хаагч хариуцлагатай жижүүрийн хуваарийн дагуу ажиллаж аймгийн хариуцлагатай жижүүрт 7037-3756 дугаарт мэдээг хүргүүлж ажилласан, байгууллага дээр ямар нэг зөрчил, ус алдалт, цонх бүрэн, хаалга хашаа, орчин тойрон тайван байсан.
- **Сонсох ажиллгаа: /ЗЕХ-ийн 27-р зүйл/**
  Газар эзэмшигчийн нэр: "БАДРАЛ ӨРГӨӨ" ХХК
  Байршил- Дархан-Уул аймгийн, Дархан сумын 13-р баг, Өмнөд үйлдвэрийн район, Дархан-2 төмөр замын өртөөний урд, Зориулалт-Төмөр замын ачиж буулгах талбай /545075 м.кв/ газрын тухай хуулийн 40.1.5, 40.16 заалтын дагуу Захиргааны үйл ажиллагааг эхлүүлхээр Сонсох ажиллагааны мэдэгдлийн төслийг боловсруулж байна

Шүүхийн мэдээлэл:

- Нэхэмжлэгч "Шинэ үе хамтын холбоо" нэхэмжлэлтэй, хариуцагчаар Аймгийн Засаг дарга, хамтран хариуцагчаар ГХБХБГ-ын дарга нарт холбогдох Дархан-Уул аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэлийн шаардлагын дагуу холбогдох тайлбарыг 2021/07/07-ны өдрийн №414 тоотоор хүргүүлсэн. Шүүх хуралдааны тов зарлагдаагүй байна.

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар:

- ГХБХБГ-т 2021 оны 6 сарын 21-ний өдрөөс 7 сарын 20-ны өдрийн хооронд абле программд нийт 91 албан бичиг /хариутай 79/, 39 өргөдөл /хариутай 39/ ирсэнээс 55 албан бичиг, 20 өргөдөл шийдвэрлэн, 24 албан бичиг, 19 өргөдөл хяналтанд бүртгэжээ.

Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:

График 1. Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлт, хяналтанд авч судлаж буй талаарх мэдээлэл



Онцгой байдлын мэдээлэл:

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдыг 30 хувиар ажлын байранд ажиллуулж, 70 хүртэлх хувийг гэрээсээ ажиллахаар хуваарь гарган, мөрдөн ажиллаж байна /хуваарийг хавсралтаар хүргүүлэв/.
- Байгууллагын байранд нийт 5 тасалгаа байгаагаас 2 тасалгаанд тус бүр нэг албан хаагч, мөн 2 тасалгаанд тус бүр 2 албан хаагч ажиллаж байна. Үлдсэн нэг тасалгаа нь иргэдэд үйлчлэх танхим байрладаг бөгөөд 10 албан хаагч ажиллаж байгааг 30 хувиар ажиллах хуваарийн дагуу өдөрт 4 хүн ажиллахаар зохион байгууллаа.
- 30 хувиар ажиллах хуваарийн дагуу ажиллахад тухайн өдөрт 30 хүртэлх хувьд тохирсон төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх боломжтой байна /цахимаар үзүүлэх үйлчилгээний жагсаалтыг хавсралтаар хүргүүлэв/.
- Ээлжээр ажиллах хуваарь, ажлын байранд үзүүлэх үйлчилгээний хуваарь, цахимаар үзүүлэх үйлчилгээ, мэдээлэл авах 70376483, 70376471 утсыг байгууллагын фэйсбүүк хаяг, байгууллагын гадна байршуулаа.

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021.06.15-ны өдрийн 01-04/05 дугаар албан даалгаврын хүрээнд цахимаар үзүүлэх үйлчилгээний жагсаалт, хариуцсан албан хаагчийн мэдээлэл

2021.06.16-2021.06.30

№	Төрийн үйлчилгээний төрөл	Хариуцсан албан хаагчийн нэр, утасны дугаар	Цахимаар үзүүлэх боломжтой үйлчилгээ /Үнэгүй нөхцөлтэй/	Ажлын байранд 30 хувиар ажилтан хуваарьлан өдөр
1	Газар эзэмшиж, ашиглах эрхийн гэрээ, гэрчилгээг шинэчлэх, кадастрын мэдээллийн сан бүртгүүлэх	Амины орон сууц гаражийн Э.Гүрэнцэц 94114540 Үйлдвэрлэл, үйлчилгээ Б.Баярмаа - 99889695	1. Жижгэлэлтийн дагуу материал бүрдүүлж, 2. Мэдээ тайлан авч бөглөж, 3. Эх хувь материалуудыг ГХБХБГ-т авчирч өгөх	Э.Гүрэнцэц - 1, 3, 5 дань, Б.Баярмаа - 2, 4 дань өдрүүдэд материал хүлээн авах боломжтой
2	Газар эзэмшиж, ашиглах эрхийн гэрээ, гэрчилгээг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн авах			
3	Газар эзэмшиж ашиглах эрхийн хугацаа сунгуулах			
4	Газар эзэмшиж эрхийн гэрчилгээг бүсдэд шилжүүлэх			
5	Хамтран эзэмшигч хасуулах, нэмүүлэх			
6	Хамтран өмчлөгч хасуулах, нэмүүлэх	Э.Гүрэнцэц - 94114540		
7	Одоо эзэмшиж байгаа газрыг өмчлөх авах			
8	Өмчлөсөн газрыг бүсдэд шилжүүлэх, хуваалцах			
9	Газар өмчлөх аваагүй тодорхойлт авах	Б.Баярмаа - 99889695	1. Жижгэлэлтийн дагуу материал бүрдүүлж, 2. Эх хувь материалуудыг ГХБХБГ-т авчирч өгөх	
10	Газар эзэмшиж байгуулагдсан төлөвлөгөөнд санал өгөх		dukhan.gov.mn болон ерөнхий веб хуудсаар хүсэлт өгөх	
11	Газар эзэмшигч, эзэмшигч, өмчлөгч кадастрын зураг авах	Б.Менчулуун - 99309990	Газрын гэрчилгээг эх хувиар авч ирэх /100190020063 данснаас 2500 төгрөг тушаасан байх, Утга: нэр, регистр/	1, 3, 5 дань өдөр материал хүлээн авах боломжтой
12	Түгээй зөвшөөрөлтэй эх газрыг нэгж байгууллагын хийсэн геодезик зураг зүйн болон кадастрын хэмжилтийн зургийг шаардах хүлээн авах, мэдээллийн сан бүртгэх		Холбогдох материалыг эх хувиар авч ирэх	
13	Газрын хэнгэртийн хэмжилт хийхтэй холбогдох мэдээлэл авах		Газрын гэрэл, гэрчилгээ, кадастрын зургийг эх хувиар авч ирэх	

- Гэрээсээ ажиллаж байгаа болон ажлын байран дээр ажиллаж байгаа албан хаагчид 7 хоног бүрийн пүрэв гаригийн 17:00 цагт ажлын тайланг Хууль эрх зүй, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэнд өгч, нэгтгэн, баасан гаригт байгууллагын даргад тайлагнаж, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлж ажиллахаар зохион байгуулсан.
- Албан даалгавар гарсанаас хойш манай байгууллагад ямар нэгэн хурал, цуглаан, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа хийгдээгүй байна.
- Албан хаагчдаас ямар нэг олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулсан, оролцсон зөрчилгүй болно.
- Албан хаагчдад аймгийн Засаг даргын 2021 оны 01-04/05 дугаар албан даалгаврыг танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулаа /гарын үсэг зуруулсан жагсаалтыг хавсралтаар хүргүүлэв/
- Ажлын байранд ариутгалыг тухай бүр хийж байна.

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ЗОЛБАЯСАХ

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН ДАРГА Г.НЯМДОРЖ